

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ

2025 оны 02 дугаар сарын 24

Улаанбаатар хот

ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН 2022-2024-ОНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Зорилго:Төвийн удирдлагын зүгээс хүний нөөцийн нийгмийн баталгаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын үзүүлэлт үр дүнг тооцон, цаашид хэрхэн сайжруулах чиглэлийг тодорхойлоход чиглэнэ.

Хүний нөөцийн нийгмийн баталгаа, ажлын байрны нөхцөлийг бүрдүүлдэг үндсэн шалгуур үзүүлэлтийг дурдвал:

1.Ажлын байр, нийгмийн баталгаа:

Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг биелүүлэн ажиллаж байгаа ажилтнуудын ажлын байрны болон цалин хөлсний баталгааг хангах.

2.Эрүүл мэндийн баталгаа:

Ажилтнуудын биеийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгийг төвийн эмч нартай хамтран зохион байгуулна. Эрүүл амьдралын дадлын нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

3.Сурч боловсрох баталгаа:

3.1.Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөө гаргаж, мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр удирдах дээд байгууллагаас зохион байгуулагдсан цаг үеийн болон мэргэшүүлэх сургалтад албан хаагчдыг хамруулж, мэргэжлээ дээшлүүлэх чиглэлээр суралцахад нь ажлын цагийн зохицуулалт хийж дэмжлэг үзүүлнэ.

3.2.Адил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтнуудыг туршлага судлуулна.

4.Амьдралын түвшний судалгаа ба баталгаа:

4.1.Төвийн ажилтнуудын амьдарч буй орон байрны судалгаа, боловсролын хөгжил, гэр бүл хүүхэд хөгжил, гэрийн гачигдал зэрэг нийгмийн асуудлын судалгаанд үндэслэн хөдөлмөрийн дотоод журмын дагуу дэмжлэг үзүүлж ажиллах.

4.2.Зөвлөлүүдийн төлөвлөгөө, үйл ажиллагааг сайжруулан ажиллах.

5.Амрах эрхийн баталгаа:

5.1.Сургалт хүмүүжлийн цогцолбор төв хотын төвлөрсөн дэд бүтэц, нийтийн тээврийн маршрутаас алслагдсан тул тус төвд ажиллах албан хаагчдад Гачууртын чиглэлд газар эзэмшүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэх.

5.2.Ажилтнуудын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

6.Ажиллах нөхцөлийн баталгаа:

Ажилтан албан хаагчдын ажлын байрны ажиллах орчныг сайжруулах, ажилтнуудад хэрэгцээтэй тоног төхөөрөмжийг ширээ сандлыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах.


7.Бусад баталгаа:

Албан хаагчдын ажлын байрны нөхцөл болон бусад судалгаанд үндэслэн “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны төлөвлөгөө” боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллах.

Ажилтан албан хаагчийн нийгмийн баталгаа, ажлын байрны
нөхцөлийг шийдвэрлэсэн байдал

1.Нийгмийн хамгааллын тусгай төвийн хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр гүйцэтгэсэн ажлын үзүүлэлтийг 2022-2023 оны байдлаар график 1-т харууллаа.

График 1



Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг биелүүлэн ажиллаж байгаа ажилтнуудын ажлын байрны тогтвортой байдал болон цалин хөлсний баталгааг хангах чиглэлээр удирдлагын зүгээс 2022-2024 онд ажилтнуудын цалингийн зэрэглэлийг 8,8 хувиар ахиулан шинэчлэн баталсан байна.


Түүнчлэн ажилтан албан хаагчдын ур чадвар, үр дүнгийн урамшууллын журмыг ажилтан бүрд гүйцэтгэлийн дагуу олгож ажиллаж байна.

График 2



2024 онд “Монгол-Япон” хамтарсан эмнэлэгт албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд АШУҮИС-ийн монгол-японы эмнэлэгтэй хамтран төвийн 30 албан хаагчдыг 12 төрлийн шинжилгээ, 3 төрлийн оношилгоо, 3 эмчийн үзлэгт тус тус хамруулан ажилласан. 2023 онд Эх нялхсын эрүүл мэндийн 2-р төвд нийт 18 ажилтныг хамруулан ажилласан байна


График 3



2024 онд “Хүний нөөцийн хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан 11 сургалтад давхардсан тоогоор нийт 44 ажилтан, 150 цагийн хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдсан. Нийгмийн хамгааллын тусгай төвөөс зохион байгуулсан 17 цаг 9 удаагийн сургалтад давхардсан тоогоор 234 ажилтан хамрагдсан байна. Албан бичгийн дагуу мэргэжлийн чиглэлээр 10 сургалтад 15 ажилтан 114 цагийн сургалтад хамрагдсан байна. Гадаад улсад мэргэжлийн чиглэлээр 80 цагийн сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан 2 ажилтан. Нийт 30 удаагийн сургалтад давхардсан тоогоор 294 ажилтан хамрагдсан.

2023 онд дотооддоо 10 ажилтан 11 удаагийн сургалт зохион байгуулж, удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн болон мэргэжил, үйл ажиллагааны чиглэлээр 34 удаагийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 43 ажилтныг хамруулж ажилласан.

График 4



Ажилтан албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах ажлын хүрээнд 2022 онд ажилтны амралтын өрөөг ашиглалтад оруулсан. 2024 онд ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан бөгөөд нийт 16,735,200 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, ажиллах нөхцөлийг сайжруулан ажилласан байна. Үүнд: Гал тогоонд 2 хаалгатай шарах шүүгээ 1 ширхэг (1,900,000), аяга таваг ариутгагч 1 ширхэг (630,000), Албан хаагчдын ажлын өрөөнд 4 ширхэг ажлын ширээ (1,343,000 төгрөг), суурин компьютер 4 ширхэг (6,517,500 төгрөг), зөөврийн компьютер 1 ширхэг (1,815,000), хэвлэгч машин 3 ширхэг (1,829,700) мөн бичиг хэргийн шүүгээ 6 ширхэг (2,700,000) төгрөг. Мөн ажилтан албан хаагчдын өрөөнд агаар цэвэршүүлэгч 4 ш (1,060,000) мөн үдийн цайны өрөөг тохижуулан ажилласан байна.


График 5



2022-2023 онд гадаад улсад хувийн зардлаараа аялалд хамрагдах болзол хангасан төвийн 3 ажилтанд нийгмийн баталгааны хөтөлбөрийн дагуу нийт 5-7 өдрийн цалинтай чөлөө олгож дэмжиж ажилласан.

2024 онд нийгмийн баталгаа, амрах аялах эрхийг хангах ажлын хүрээнд нийт 11 ажилтныг Төвийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу 5-7 өдрийн цалинтай чөлөө олгож гадаадад аялах, амрахад дэмжлэг үзүүлэн ажилласан.

График 6



2022 онд нийгмийн баталгааг хангах чиглэлээр 3,000,000 төрөг батлагдсан бөгөөд ахмад ажилтан 4, ажилтны хүүхэд 18, шагнал урамшуулалд 2, сургалтын төлбөрт 1 тэтгэмжид 1 ажилтныг тус тус хамруулан хүргэн ажилласан байна.

2023 онд нийгмийн баталгааг хангах чиглэлээр 5,000,000 төгрөг батлагдсан үүнээс ахмад ажилтан 5, ажилтны хүүхэд 20, шагнал урамшуулалд 3, ар гэрийн гачигдал 1 ажилтныг тус тус хамруулан ажилласан байна.

2024 онд Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр тусгагдсан 12 сая төгрөгийг давхардсан тоогоор 90 хүнд (ажилтны 26 хүүхэд, төвөөс тэтгэвэрт гарсан давхардсан тоогоор 10 ажилтан, төвийн 54 ажилтан давхардсан тоогоор) хүрч ажилласан байна.

Дүгнэлт

1.Удирдлагын зүгээс гүйцэтгэсэн томоохон ажил бол 2022-2024 оны ажилтнуудын цалингийн зэрэглэлийг 8,8 хувиар ахиулж албан хаагчдын нийгмийн баталгаа ажлын байрны тогтвортой байдлыг ханган ажилласан байна.

2.2023 онд Төвийн 20 жилийн ойн баярыг үе үеийн ажилтан албан хаагчид болон хамтын ажиллагааны байгууллагаас 13,7 сая төгрөгийн хандивын төсөв бүрдүүлэн ойн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

3.2023 онд Тус төвийн чиг үүргийн байгууллагатай хамтын үйл ажиллагааг сайжруулж, хүний нөөцийн сургалт хөгжлийг буюу мэргэжлийн сургалтад ажилтан албан хаагчдын оролцоог 2 дахин нэмэгдүүлсэн байна.

4.Мөн 2023-2024 онд иргэдийн үйлчилгээ болон төвийн үйл ажиллагаанд ашиглах (178,547,190) төгрөгийн 3 автомашинтай болж төрийн албаны цэнхэр дугаарын журмыг хэрэгжүүлэн ажилласан.

5.2024 онд Төвийн үйл ажиллагааны хэрэгжиж буй дүрэм журмыг шинэлэн баталсан үүнд: түр хоноглох байр болон зөвлөлүүд, үр дүн, ур чадвар, автомашин ашиглах журмыг зэргийг шинэчлэн баталсан байна.

6.2024 онд Төвийн албан хаагчдын амрах эрхийн баталгааг ханган ажилласан бөгөөд нийт 9 албан хаагчдыг 5-7 хоногийн гадаадад аялан амрах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Мөн 2 ажилтныг гадаад туршлага солилцох боломжийг ханган ажилласан.

7.2024 онд нийт албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр тусгагдсан 12 сая төгрөгийг давхардсан тоогоор 90 хүнд (ажилтны 26 хүүхэд, төвөөс тэтгэвэрт гарсан давхардсан тоогоор 10 ажилтан, төвийн 54 ажилтан давхардсан тоогоор) хүрч ажилласан байна.

8.2023 онд өнгөт хувилагч машинтай, 2024 онд ажлын байрны тоног төхөөрөмж 1,039.500 төгрөг, ажлын ширээ, сандал, шүүгээ,компьютер, агаар цэвэршүүлэгч зэрэгт 11,9000 төгрөг нийт 20,0000 сая төгрөгийн тохижилт хийн ажилласан байна.

СУДАЛГАА ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН, СЭТГЭЛ ЗҮЙЧ

Б.БАЛЦЭЦЭГ